



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/М

Шивээговь сум

“3 дугаар сургууль камержуулах” ажлын
барааг хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “3 дугаар сургууль камержуулах” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Э.Халиун (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:


П.Дэлгэрбаяр (Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)

Б.Энхмаа (Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч)

Ж.Баярцэцэг (3 дугаар сургуулийн багш)

2. Худалдан авах ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулан гүйцэтгэлийг хангуулж, акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ